



# Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн

## ТОГТООЛ

1964 оны 4 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 194

Улаанбаатар  
хот

Улсын Банкны Ерөнхий Хорооны  
зохион байгуулалтанд өөрчлөлт  
оруулах тухай

Улсын Банкны Ерөнхий Хорооны ажлын нийт хэмжээ үлэмж өсөн, орон нутагт харьяа салбар байгууллагуудын тоо олширч байгааг харгалзан, **БНМА Улсын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:**

1. Улсын Банкны Ерөнхий Хорооноос Нийслэл Улаанбаатар хотын үйлдвэр, аж ахуйн болон төсвийн бүх байгууллагуудын зээл тооцоо, мөнгөн эргэлтийн ажлыг хариуцсан Улаанбаатар хотын банкны конторыг 1964 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн тусгаарлан байгуулахыг Улсын Банкны Ерөнхий Хороо /н.ЛХАМСҮРЭН/-д зөвшөөрсүгэй.

2. Улаанбаатар хотын банкны конторт нийслэлийн Толгойт, Налайхын районн банкны хэлтэс, хороодын ардын депутатын хурлын гүйцэтгэх захиргаадыг түшиглэн байгуулагдсан хадгаламжийн кассуудыг харьяалуулсугай.

3. Улаанбаатар хотын банкны конторыг тусгаарлан байгуулсантай холбогдуулан, Улсын Банкны Ерөнхий Хорооны зохион байгуулалт, орон тоог 60 нэгж, сарын цалингийн фондыг 42 000 төгрөгөөр хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

4. Улсын Банкны Ерөнхий Хороо, Улаанбаатар хотын банкны конторын орон тоог Улсын Банкны Ерөнхий Хорооны 1963 онд байсан нийт орон тоо, цалингийн фондод багтаахаар бодож, Улаанбаатар хотын банкны конторын орон тоо, цалинг хянан батлаж өгөхийг

Хөдөлмөр, Налин Хөлсний Улсын Хороо /н.ШАРАВ/-д даалгасугай.

5. Улсын Банкны Ерөнхий Хорооны нэг орлогч дарга нь  
Улаанбаатар хотын банкны конторын дарга байхаар тогтоосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан, БНМА Улсын Сайд  
нарын Зөвлөлийн 1961 оны 679 дүгээр тогтоол, 1962 оны 828  
дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн "в" заалт, 1968 оны 146  
дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Б Н М А Улсын Сайд нарын  
Зөвлөлийн I-р орлогч дарга.


ЛУВСАН

Б Н М А Улсын Сайд нарын  
Зөвлөлийн Хэрэг эрхлэх  
газрын дарга

БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн  
эрхлэгч



 / ДАГВАДОРЖ /

Сайд нарын Зөвлөлийн 1964 оны  
194 дүгээр тогтоолын хавсралт.

Улсын Банкны Ерөнхий Хорооны  
зохион байгуулалт, орон тоо,  
сарын цалингийн фонд

№:	Зохион байгуулалт, албан тушаал	: орон : сарын : тоо : цалин	: сарын : цалингийн : фонд
----	---------------------------------	---------------------------------	----------------------------------

I. Удирдах хэсэг.

1:	Ерөнхий Хорооны дарга	I ✓ 1500	1500
2:	I-р орлогч дарга	I ✓ 1350	1350
3:	Орлогч дарга	I ✓ 1200	1200
4:	Орлогч дарга бөгөөд хөрөнгө оруулалтын санхүүжүүлэх газрын дарга	I 1200	1200
5:	ЭЭХТЗ-ийн болон олон улсын банкны ажил эрхэлсэн референт	I ? 800	800
6:	Улсын ерөнхий нярав	I ✓ 800	800
7:	Нарийн бичгийн дарга бөгөөд тогтоол тушаалын биелэлтийн байцаагч	I ✓ 550	550
		<u>ДҮН</u> 7	7400

II. Зээл мөнгөн эргэлтийн хэлтэс.

1:	Хэлтсийн дарга	I 850	850
2:	Үйлдвэр хариуцсан мэргэжилтэн	I 750	750
3:	Худалдаа хариуцсан мэргэжилтэн	I 750	750
4:	Зээл кассын төлөвлөгөөний мэргэжилтэн	I 750	750
5:	Хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй хариуцсан мэргэжилтэн	2 750	1500
6:	Байцаагч	2 550	1100
		<u>ДҮН</u> 8	5700



2.

III. Төв нягтлан бодох хэлтэс .

1: Ерөнхий нягтлан бодох бөгөөд хэлтсийн дарга	I	850	850
2: Мэргэжилтэн	I	750	750
3: Нягтлан бодох бүртгэлийн зааварлагч	3	550	1650
4: Төсөв, орсон тоо, зохион байгуулалтын байцаагч	I ?	650	650
5: Үнэт металл шалгах тасгийн эрхлэгч бөгөөд лабораторийн эрхлэгч	I ✓	800	800
6: Үнэт металлд чанар шалгах химийн мэргэжилтэн	I ✓	750	750
7: Ерөнхий хорооны үнэт металл, валютын бондыг хариуцсан нягтлан бодогч	I ✓	600	600
8: Системийн хоорондын тооцооны нягтлан бодогч	4 ✓	550	2200
	<b>ДҮН</b>	<b>13</b>	<b>8250</b>

IV. Шалган байцаах хэлтэс .

1: Хэлтсийн дарга	I ✓	850	850
2: Ахлах байцаагч	I ✓	650	650
3: Байцаагч	2 ✓	600	1200
	<b>ДҮН</b>	<b>4</b>	<b>2700</b>

V. Боловсон хүчний хэлтэс .

1: Хэлтсийн дарга	I ✓	850	850
2: Тусгай хэргийн эрхлэгч	I ✓	650	650
	<b>ДҮН</b>	<b>2</b>	<b>1500</b>

VI. Бичиг хэрэг .

1: Бичиг хэргийн эрхлэгч	I ✓	450	450
2: Экспедитор /ротаторчин/	I ✓	450	450
3: Ахлах бичээч	I	360	360
4: Бичээч	I	340	340
	<b>ДҮН</b>	<b>4</b>	<b>1600</b>

Уп. Гадаад гүйлгээний газар.

Газрын дарга I ✓ 1000 1000

I. Валют-эдийн засгийн хэлтэс

- 1: Газрын орлогч бөгөөд хэлтсийн дарга I ✓ 850 850
- 2: Урт хугацаатай зээлийн мэргэжилтэн I 750 750
- 3: Худалдаа<sup>хс</sup> зээл-эдийн засгийн мэргэжилтэн I 750 750
- 4: Олон талт тооцооны мэргэжилтэн I 750 750
- 5: Валютын мэргэжилтэн I 750 750
- 6: Худалдааны бус тооцоо эрхэлсэн байцаагч I 650 650
- 7: Хуулийн мэргэжилтэн бөгөөд орчуулагч I 750 750

2. Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс

- 1: Газрын ерөнхий нягтлан бодогч бөгөөд хэлтсийн дарга I 850 850
- 2: Журналын нягтлан бодогч I 550 550
- 3: Худалдааны бус тооцооны хянагч I 700 700
- 4: Мөн нягтлан бодогч 2 600 1200
- 5: Худалдааны тооцооны хянагч I 700 700
- 6: Мөн нягтлан бодогч 2 600 1200
- 7: Хятад гуйвуулагын хянагч I 600 600
- 8: Дотоодын тооцооны нягтлан бодогч 2 600 1200
- 9: Экспедитор I 500 500
- 10: Бичээч /орос/ I 450 450
- 11: Кассын нярав I 500 500

ДҮН 22 14850  
 БҮГД 60 42000